



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 08 дугаар сарын 30

Дугаар А/112

Баян-Өндөр сум

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XVI хуралдааныг 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1.Эрдэнэт хот, Хөдөө аж ахуйн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдлын тухай

1.2.Орхон аймаг, Эрдэнэт хотын 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай

1.3.Сүм хийдийн үйл ажиллагаа явуулах хугацаа сунгах тухай


1.4.Хот тохижуулах газар, Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын бүтэц, орон тоо, цалингийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

1.5.Бусад

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ